



Дараах зураг болон мэдээллийг ашиглан 1 – 2 дугаар даалгавруудыг гүйцэтгээрэй.



Монгол бөх бол олон хувилбар баялаг мэхтэй, барьцтай, барьцгүй, хав дөрвөлжин золгож барилддагаараа онцлогтой. Монгол бөхийн мэхний талаар эрдэмтэн судлаач нар янз янзаар бичдэг бөгөөд хамгийн багаар бодоход үндсэн **45** мэхтэй байдаг байна.

эх сурвалж: <https://news.mn/>

- Зурагт аль нь хамгийн хамааралтай вэ?
A. соёлын даяаршлын үзэл санаа
C. дангаарчлалын үзэл санаа
B. спортын хөгжлийн үзэл санаа
D. нийгмийн даяаршлын үзэл санаа
- Эрдэмтдийн судалгааг үнэн бодит тоо баримттай болгохын тулд аль судалгааны арга нь хамгийн оновчтой вэ?
A. харьцуулалтын арга
C. асуултын арга
B. ажиглалтын арга
D. ярилцлагын арга
- Хөдөөгийн суурин газрыг илэрхийлэх зургийг сонгоорой.



- A. B. C. D.
- Фермүүд ус, тэжээл, эрчим хүчний хэрэглээгээ хянаж, малын хаягдал дахин боловсруулалтыг тогтмол хийх ямар давуу талтай вэ?
A. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулна
B. Бэлчээрийн талбайг нэмэгдүүлнэ
C. Хүний оролцоог нэмэгдүүлж, ашиг шим өснө
D. Малын өвс тэжээлийн өртөг, зардал өснө
 - Дараах улсуудаас аль нь цагаан будааны гол үйлдвэрлэгч орон бэ?
A. Монгол
B. Канад
C. Хятад
D. Норвеги
 - Аль нь дэлхийн дулаарлын үр дагаварт ХАМААРАЛГҮЙ вэ?
A. үерийн аюул нэмэгдэнэ
B. ойн түймэр ихэснэ
C. цөлжилт нэмэгдэнэ
D. хүн ам ихэснэ
 - Аль нь төрийн үйлчилгээнд хамаарах вэ?
A. Үүрэн холбооны интернэт суурилуулалт
B. Нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээ
C. Хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа
D. Бүх нийтээрээ мод тарих үйл ажиллагаа
 - Хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах байгууллагыг сонгоорой.
A. “Цемент шохой” ХХК
B. “Дархан нэхий” ХК
C. “Оюу толгой” ХХК
D. “Шунхлай” ХХК

Зураг болон мэдээллийг ашиглан 9 – 11 дүгээр даалгавруудыг гүйцэтгээрэй.

Дэлхийд төрөлх хэлтний тоогоор Испани хэл нь Хятад (мандарин) хэлний дараа хоёрдугаарт орох ба 540 сая гаруй хүн ярьдаг.

Төрөлх Испани улсаас гадна 20 улсын албан ёсны хэл болдог.

XV – XIX зуунд Испани улс, Америк тив, Карибын тэнгис, Африкийн зарим хэсгийг колоничилж, Испаничууд тархан суурьшиж байв. Энэ хугацаанд төрийн удирдлага, хууль тогтоомж, боловсрол, шашны үйл ажиллагааг испани хэлээр явуулсан байна.

XIX зуунд эдгээр орнууд тусгаар тогтносон ч олон үндэстэн, олон хэлтэй нийгмийг нэгтгэхийн тулд аль хэдийн түгээмэл хэрэглэгдэж байсан Испани хэлийг албан ёсны хэлээр хадгалсан юм.



9. Испани хэлийг аль тивийн улс орнууд хамгийн их ашиглаж байна вэ?
A. Африк B. Европ C. Ази D. Америк
10. Испани хэлийг олон улс орнууд албан ёсны хэлээ болгоход хүн амын шилжилт хөдөлгөөн хэрхэн нөлөөлсөн байж болох вэ?
A. Испани хэл зөвхөн цэргийн хүрээнд хэрэглэгдэж байсан учир улс орнуудаас ирсэн цэргүүд сурах шаардлага үүсдэг байсан.
B. Испаниас ирсэн хүмүүс очсон улсууддаа байнгын суурьшил үүсгэн өөрсдийн хэлээ өдөр тутмын амьдралд ашиглаж байсан.
C. Тухайн улс орнуудын уугуул иргэд испани хэл сурахгүй байсан учир шилжин ирж буй хүмүүс нь л ашигладаг байсан.
D. Хүн амын шилжилт хөдөлгөөн хэлний хэрэглээнд төдийлөн нөлөө үзүүлэхгүй бөгөөд хэл сурах эсэх нь эрх чөлөөтэй байсан.
11. Африк тивээс ганцхан Экваторын Гвиней улсад одоог хүртэл Испани хэл албан ёсны хэвээр байгаагийн бодит шалтгаан аль нь вэ?
A. Африкийн бүх улс испани хэл хэрэглэдэг байгаад больсон учир.
B. Дэлхийн улс орнуудаас төрөлх хэлний хэрэглээгээр Испани хэл 2-т ордог учир.
C. Колоничлолын үед боловсролоо испани хэлээр эзэмшиж хэвшсэн учир.
D. Зөвхөн шашны үйл ажиллагаа нь испани хэлээр явагддаг учир.
12. Олон улсын спортын аялал жуулчлалын төрлийг илэрхийлэх жишээг сонгоорой.
A. Бостон хотод зохиогдох олон улсын марафонд оролцох.
B. Танзаний саванн дахь Африкийн амьтдын судалгаа хийх.
C. Шотландын үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээр алхах.
D. Австралийн далайн экосистемийн судалгаа хийж алхах.

13. Орон нутгийн иргэдэд аялал жуулчлалын үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөг зөв ялган тодорхойлсон хувилбарыг сонгоорой.

№	Үр нөлөө	эерэг	сөрөг
1	Нутгийн соёл даяарших үйл явц нэмэгдэнэ.		
2	Байгаль орчны бохирдол нэмэгдэнэ.		
3	Гаднаас импортын бараа бүтээгдэхүүн нэмэгдэнэ.		
4	Орон нутгийн иргэдийн амьжиргаа нэмэгдэнэ.		
5	Гадаадаас ирэх жуулчдын тоо нэмэгдэнэ.		

A. 1-Э, 2-С, 3-С, 4-Э, 5-Э

B. 1-С, 2-С, 3-Э, 4-Э, 5-Э

C. 1-Э, 2-Э, 3-Э, 4-С, 5-С

D. 1-С, 2-С, 3-С, 4-Э, 5-Э

14. 2023 онд нийт үйлдвэрлэсэн махны хамгийн их хувийг эзлэх төрлийг тодорхойлон, нийт махны хэдэн хувийг эзэлж байгааг зөв тооцоолсон хувилбарыг сонгоорой.

ДЭЛХИЙН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ /сая тонн/



эх сурвалж: <https://www.statista.com/>

A. гахай – 39.5%

B. тахиа – 20.9%

C. гахай – 33.5%

D. тахиа – 39.2%

15. Диаграммыг ажиглан тохирох дүгнэлтийг сонгоорой.

- A. Сүүлийн жилүүдэд техник, технологи хөгжихийн хэрээр мах орлуулагч бүтээгдэхүүн нэмэгдэж байгаа учир махны хэрэглээ, үйлдвэрлэлийн өсөлт бага байгаа нь харагдаж байна.
- B. Ковид-19 цар тахлын үед үйлдвэрлэл, хангамжийн сүлжээнд олон тасалдал үүссэн бөгөөд тухайн цаг үед махны хэрэглээ буурсан байгаа нь харагдаж байна.
- C. Хүн амын тоо тогтмол өсөхийн хэрээр тухайн улс орнуудын махны хэрэглээний өсөлт үүнийг дагаж өссөөр байгаа нь харагдаж байна.
- D. Хүмүүсийн махны хэрэглээ тахиа, гахайны махыг голлон хэрэглэж байгаа учир бусад төрлийн махыг хэрэглэхээс татгалзаж байгаа нь харагдаж байна.

16. Экологийн ул мөр гэдэг нь бидний амьдралын хэв маяг байгаль орчинд ямар хэмжээний ачаалал өгч байгааг илэрхийлдэг тооцоолол юм.

Жишээлбэл: Монголчуудын нэг хүнд ногдох дундаж ул мөр нь 6.1 га байдаг бөгөөд нэг хүн жилд дунджаар 1200 кВт цахилгааныг хэрэглэдэг гэж үзвэл нэг хүний жилийн дундаж экологийн ул мөр хэд байхыг тооцоолж олоорой. (1 кВт.цаг цахилгаан = 0.0005 га экологийн ул мөр)

A. 0.6 га

B. 3.6 га

C. 6.1 га

D. 6.8 га

Мэдээллийг ашиглан 17 -21 дүгээр даалгавруудыг гүйцэтгээрэй.

Венесуэл улсын газрын тосны экспорт болон олборлолт



source: tradeimex.in


Венесуэл бол дэлхийн хамгийн их газрын тосны нөөцтэй (303 тэрбум баррель) орон бөгөөд маш өтгөн тос учраас уур шахах, химийн бодис ашиглах, гүн өрөмдлөг зэрэг өндөр технологи шаардагддаг.

Венесуэл улс газрын тосны асар их нөөцтэй боловч олборлолт, боловсруулах аж үйлдвэр нь дэд бүтэц, технологийн дутагдал, улс төр-эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалан сул хөгжсөн.

- Газрын тос нь аж үйлдвэрийн аль салбарын голлох түүхий эд вэ?
 - Уул уурхайн үйлдвэр
 - Машины үйлдвэр
 - Химийн үйлдвэр
 - Түлшний үйлдвэр
- Газрын тосыг их хэмжээгээр, зардал бага тээвэрлэхэд аль нь хамгийн тохиромжтой вэ?
 - усан тээвэр
 - дамжуулах хоолойн тээвэр
 - төмөр замын тээвэр
 - авто замын тээвэр
- Венесуэл улсын газрын тосны экспорт болон олборлолтын график ашиглан оновчтой дүгнэлт гаргасан хувилбарыг сонгоорой.
 - Сүүлийн 10 жилд газрын тосны олборлолт тогтмол нэмэгдэж, түүнийг даган экспортын үнэ тогтмол өссөн байна.
 - 2020 – 2023 онд газрын тосны экспортын хэмжээ огцом буурсан ч олборлолт тогтмол нэмэгдсэн байна.
 - Сүүлийн 10 жилд газрын тосны олборлолт тогтмол буурч, экспортын үнэ ч түүнийг даган багассан байна.
 - 2014 – 2016 онуудад газрын тосны олборлолт тогтмол өссөн хэдий ч экспортын хэмжээ буурсан байна.
- Венесуэлийн газрын тосны үйлдвэрлэлийн хөгжил сул байхад хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл аль вэ?
 - Газрын тосны хэт их түүхий эдийн нөөцтэй учир ажиллах хүч дутагдалтай.
 - Хуучин тоног төхөөрөмжийн шаардлага хангахгүй учир техникийн хомсдолтой.
 - Далайд гарцтай орон учир эдийн засагт далайн тээвэр голлох ач холбогдолтой.
 - Зөвхөн өөрсдөө олборлолт хийдэггүй олон гадаадын компаниудын оролцоотой.

21. Венесуэл улс экологийн тэнцвэртэй байдлаа хадгалж, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх хамгийн боломжит арга аль нь вэ?
- А. Дэвшилтэт өндөр технологийг оновчтой сонгон ашиглаж, өрөмдлөг хийж олборлолт хийсний дараа нөхөн сэргээлтийг тогтмолжуулах.
 - В. Газрын тосны нөөцийг хамгаалж бусад улс орнууд руу экспортлохгүйгээр дэд бүтэц, эдийн засгаа хөгжүүлэх.
 - С. Хуучин тоног төхөөрөмжүүдээ үргэлжлүүлэн ашиглаж, байгаль орчны тэнцвэртэй байдалд анхаарч ажиллах.
 - Д. Үйлдвэрийн тоог нэмэгдүүлэн олон төрлийн химийн бодис ашиглаж, гүн өрөмдлөгийг өдөр тутамд хийж эрчимжүүлэх.
22. НҮБ-ээс гаргасан хүний хөгжлийн индексийг тооцсон 2025 оны тайлангийн илтгэл дэх үр дүнг зургаар харуулав. Монгол улсын хүний хөгжлийн индексийн үзүүлэлт хэдээс хэдэн онд хамгийн их өсөлттэй байна вэ?

Монгол улсын ХХИ-ийн чиг хандлага / 1990 - 2023 он /



- A. 2017 – 2018 онд
 - B. 2019 – 2020 онд
 - C. 2021 – 2022 онд
 - D. 2018 – 2019 онд
23. Монгол улсын хүний хөгжлийн индексийн бууралт хамгийн өндөр байсан хугацааг тодорхойлж, нөлөөлсөн хүчин зүйлийг холбон тайлбарласан хувилбарыг сонгоорой.
- A. 1990 – 1994 онд, учир нь энэ үед манай улсын насанд хүрсэн хүмүүсийн бичиг үсэгт тайлагдсан байдал бага байсан.
 - B. 2018 – 2022 онд, учир нь энэ үед манай улсын хүн амын урт удаан, эрүүл аюулгүй амьдрах нөхцөл багасаж дундаж наслалтын түвшин буурч байсан.
 - C. 1991 – 1993 онд, учир нь энэ үед манай улсын амьжиргааны түвшин доогуур, картын бараанд шилжиж нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ бага байсан.
 - D. 2019 – 2021 онд, учир нь энэ үед манай улс төдийгүй дэлхийд цар тахал дэгдэж нүүрсний экспорт багассанаас нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ багассан байна.

24. Зураг болон мэдээллийг ашиглан хүснэгт дэх асуултуудад тохирох хувилбарыг зөв тодорхойлсныг сонгоорой.

Өмнөд Солонгос улсын Сөүл хот дахь Хан голд байгуулсан NODEUL ISLAND хиймэл арлыг зурагт харуулав.

Уг арлыг 4 жилийн засварын төслийн дараа хөгжмийн сэдэвтэй соёлын цогцолбор болж 2019 оны 9-р сарын 28-нд дахин нээгджээ. Арал дээр задгай хөгжмийн талбай, номын дэлгүүр, ногоон байгууламж бүхий том задгай талбай зэрэг төрөл бүрийн соёлын байгууламжууд байдаг.

Google map



2004 он



2024 он



№	Google Earth ашиглан 2004 болон 2024 оны ялгааг харахад аль цэсийг ашигласан бэ?	№	2004 – 2024 оны хооронд тухайн арлын гадаргад ямар өөрчлөлт гарсан байна вэ?	№	Тус арлыг шинэчлэх болсон гол зорилгыг оновчтой таамагласан хувилбарыг сонгоорой.
1		A	Хүрээлэн буй орчны бохирдол багассан	a	Хот дотор барьсан учир хот төлөвлөлтийн жишиг төслийн загварчлал, үзэсгэлэн болгох ашиглах.
2		B	Барилга, байгууламж нэмэгдсэн	b	Хиймэл арал учир соёл урлагийн төв, чөлөөт цагийг өнгөрүүлэх хангалттай талбай нь аялал жуулчлалын хөгжлийг дэмжих.
3		C	Хан голын усны түвшин нэмэгдсэн	c	Голын дунд байгуулсан учир эко ногоон орчин бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн жишиг төв болгох.
4		D	Ногоон орчны хэмжээ багассан	d	Задгай талбай ихтэй учир залуучуудад урлагийн үйл ажиллагааг зохион байгуулах хамгийн чөлөөт, таатай талбар бий болгох.


A. 4, D, d

B. 2, C, a

C. 4, B, b

D. 2, A, c

Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн амын хэтийн шинэчилсэн тооцоогоор 2033 онд 4 сая, 2048 онд 5 сая хүрэх төлөвтэй гэсэн тооцоолол гарсан байна.



4. Үндэсний статистикийн хорооны тооцооллоос илүү буюу 3 сая гаруй хүний зөрөөтэй байна.